



**МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,
Утас: 264216, Факс: 264460,
E-mail: info@csc.gov.mn

2021.01.08 № 03/27
танай _____-ны № _____-т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Ц.МӨНХБАТ ТАНАА

С. Хулануу
Тогтоолын хэрэгжилтийг
тангачуулах

Ц.Мөнхбат 2/19

Тогтоол хүргүүлэх тухай

Таны энэ өдрийн мэндийг эрье.

Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 04 дүгээр тогтоолыг хүргүүлж байна.

Танай аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар ажиллаж байсан Ц.Эрдэнэсүрэн Төрийн албаны зөвлөлд хандаж гомдол гаргасан тул маргаан хянан шалгах журмын дагуу магадлан шалгаж байгаа болно.

Иймд маргаан шийдвэрлэгдэж, Тамгын газрын даргын албан тушаал хууль ёсны томилгоотой болох хугацаанд орон нутаг дахь төрийн албаны хүний нөөцийн сонгон шалгаруулалт, томилгоо болон бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэвийн тасралтгүй байдлыг хангах үүднээс Төрийн албаны зөвлөл өөрийн бүрэн эрхийн хүрээнд энэ шийдвэрийг гаргасан болохыг үүгээр мэдэгдэж байна.

Харьяалах нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий засаг төрийн төлөөлөгчийн хувьд Та орон нутагтаа төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжин ажиллахыг танд зөвлөө.

Төрийн албаны зөвлөлийн тогтоол, зөвлөмжийг хавсаргав.

Хувийг Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлд.

Хавсралт...хуудас.

ГИШҮҮН



С.ЦЭДЭНДАМБА

21300057



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

᠒᠐᠒1 оны ᠐1 сарын ᠐8 өдөр

Дугаар ᠐4

Улаанбаатар хот

Салбар зөвлөлийн даргын
үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.3, 65.6 дахь хэсэг, “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 2.1.10 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 4.3.5, 5.12 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн даргын албан үүргийг салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоожоор түр орлон гүйцэтгүүлсүгэй.

2.Төрийн албаны тухай хууль тогтоомж, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж, салбар зөвлөлийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Салбар зөвлөлийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Мөнгөнцоож/-д үүрэг болгосугай.

3.Салбар зөвлөлийн үйл ажиллагааг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанд даалгасугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ

210000010



МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ЗӨВЛӨМЖ

2020 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Төрийн албаны хууль тогтоомжийг
хэрэгжүүлэх тухай

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Сонгуулийн үр дүнгээс үл хамааран төрийн албан хаагч тогтвортой ажиллах нөхцөл бүрдэж, төрийн албаны шатлан дэвшүүлэх тогтолцоо боловсронгуй болсон байна” гэж тодорхойлсон. Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-д “Энэ хуульд заасан журмын дагуу төрийн албан хаагчийг сонгон шалгаруулж томилоход ...төсвийн ерөнхийлөн захирагч, улс төрийн албан тушаалтан, улс төрийн нам, эвслийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, бусад этгээдийн зүгээс аливаа хэлбэрээр нөлөөлөх, дарамт, шахалт үзүүлэхийг хориглоно” гэж заасан билээ. Төрийн албаны удирдах албан тушаалтан нь Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон хууль дээдлэх төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах үүрэгтэй.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн дүнгээр нутгийн өөрөө удирдах байгууллагуудыг байгуулж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагыг сонгох, нэр дэвшүүлэх, томилох үйл ажиллагаатай холбогдуулан ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Бүх шатны Засаг даргад нэр дэвшүүлэхдээ Төрийн албаны тухай хууль болон Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан болзол, шаардлагыг бүрэн хангасан иргэнийг санал болгохыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд;

Хоёр. Сонгуулийн дүнгээр аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх дуусгавар болох, төрийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч болон шууд захирагч өөрчлөгдөх нь төрийн албан хаагчийг өөрчлөх үндэслэл болохгүй гэж заасан Төрийн албаны тухай хуулийн хэм хэмжээг чанд хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга, төсвийн шууд захирагч нарт;

Гурав. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төрийн байгууллагуудын хүний нөөцийн томилгоонд шууд болон шууд бус аливаа хэлбэрээр оролцох, нөлөөлөх, дарамт, шахалт үзүүлэхийг хориглосон Төрийн албаны тухай хуулийн заалтыг хэлбэрэлтгүй баримтлахыг улс төрийн бүх албан тушаалтнуудад тус тус зөвлөж байна.

Зөвлөмж болгож буй эдгээр асуудлаар төрийн албаны хууль тогтоомжийг зөрчвөл тухайн албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, эсхүл огцруулах үндэслэл болохыг онцгойлон анхааруулъя.

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

